



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/204

Арвайхээр сум


Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.14, Улсын Их Хурлын 2023 оны “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 59 дүгээр тогтоолын 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг орон нутагт хэрэгжүүлж, тайлагнах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан, биелэлтийн нэгдсэн дүнг, 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Авлигатай тэмцэх газарт тус тус хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (О.Сумъяасүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0434

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2024 оны 3 дугаар  
сарын 23-ны өдрийн 10 дугаар  
захирамжийн хавсралт



**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ОРОН НУТАГТ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: О.Сумъяасүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Н.Энхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

А.Отгонцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын  
хэлтсийн дарга)

Б.Сайнбилэг (аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын эрх зүй, хяналтын хэлтсийн Гэмт хэргээс  
урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн)

Г.Пүрэвдорж (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын  
хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны  
газрын дарга)

Д.Өсөх-Эрдэнэ (аймгийн Засаг даргын эрхлэх  
асуудлын хүрээний агентлаг Соёл, урлагийн газрын  
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Сумдын Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Д.Мөнхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)